

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БУЙ ТӨСВИЙН ТӨВЛӨРӨЛ, ЭС
ТӨВЛӨРЛИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**
(ДҮН ШИНЖИЛГЭЭ)

*Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Батдорж, Г. Билгээ,
Ц. Болормаа, Б. Дуламсүрэн, Ч. Онончимээ*

**ШИНЭЭР БАТЛАГДСАН “ТӨСВИЙН ТУХАЙ” ХУУЛЬ ДАХЬ ТӨСВИЙН ТӨВЛӨРӨЛ, ЭС ТӨВЛӨРЛИЙН
ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ**

Тус Судалгааны төв нь Улсын Их Хурлын гишүүн Р. Гончигдоржоос ирүүлсэн захиалгын дагуу СТ - 12/501 дугаартай “Монгол улсын төсвийн харилцаан дахь төсвийн төвлөрлийн асуудал, төсвийн тухай хууль тогтоомжуудад хийсэн дүн шинжилгээ” -г өмнө нь хийж гүйцэтгэсэн болно. Уг судалгаанд төсвийн төвлөрөл, эс төвлөрлийн үзүүлэлтийн талаар онол арга зүйн үндсүүдийг тодорхойлон гаргасан. Түүнчлэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль” /1992-2002/, “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” /2002-2011/, “Төсвийн тухай” /2011/ зэрэг хуулиудад төсвийн төвлөрөл, эс төвлөрлийн дүн шинжилгээ хийсэн.

Энэ удаагийн судалгааг өмнөх судалгаанд тулгуурлан 2011 онд шинэчлэн батласан Төсвийн тухай хуулиар зохицуулж буй төсвийн төвлөрөл, эс төвлөрлийн байдалд дүн шинжилгээг хийлээ. Улсын төсвийн төвлөрсөн, эс төвлөрсөн байдлыг илтгэдэг гол үзүүлэлтүүд ДНБ -д эзлэх орон нутгийн төсвийн орлого болон Улсын төсвийн орлогод орон нутгийн орлогын эзлэх хувь болохыг тодорхойлсон байдаг. Иймээс судалгааг гүйцэтгэхдээ одоо мөрдөгдөж байгаа 2002 оны Нэгдсэн төсвийн тухай хууль болон 2013 оноос мөрдөгдөж эхлэх Төсвийн тухай хуулиудын улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын талаар холбогдох заалтуудыг харьцуулан авч үзлээ. Үүнд дээр үндэслэн Сангийн яамнаас гаргасан 2013 - 2015 оны төсвийн төсөөлөлийн тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

Нэг. Хуулийн харьцуулалт

| Нэгдсэн төсвийн тухай хууль /2002 он/ | Төсвийн тухай хууль /2011 он/ | Товч тайлбар /Дэлгэрэнгүйг дүгнэлт хэсгээс харна уу/ |
|--|--|---|
| Улсын төсвийн татварын орлого | | |
| <ul style="list-style-type: none"> • ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувь /9.1.6/ • ашигт малтмалын хайгуулын болон ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувь /9.1.7/ | <ul style="list-style-type: none"> • ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /23.4.6/ • ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр /23.4.7./ | Энэ төрлийн төлбөрүүдийг 100% улсын төсөвт хурааж авч байгаа нь төсвийн төвлөрөл өндөр байгааг харуулж байна. |
| Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого | | |
| <ul style="list-style-type: none"> • ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 20 хувь /10.1.2/ • ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25 хувь /10.1.6/ | – | Энэ төрлийн төлбөрүүдийг 100% улсын төсөвт хурааж авч байгаа нь төсвийн төвлөрөл өндөр байгааг харуулж байна. |

Судалгааны эмхтгэл, XIII боть

| | | |
|---|---|---|
| <ul style="list-style-type: none"> Ус ашигласаны төлбөр нь сумын төсвийн орлогод хамаарна. | <ul style="list-style-type: none"> үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр /23.6.5/ | Усны төлбөрийг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах гэж ялгаад сум дүүргээс аймаг, нийслэлрүү татаж оруулсан нь төсөв төвлөрч байна. |
| — | <ul style="list-style-type: none"> өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар /23.6.7/ | Энэ төрлийн татвар шинээр бий болгож орон нутагт шилжүүлсэн нь төсвийн төвлөрийг сааруулах алхам болсон. |
| | <ul style="list-style-type: none"> энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж /23.6.8/ | Өмнө нь Тэмдэгтийн хураамжийн тухай хуулин зөвхөн 35-р зүйлд заасан төлбөр хураамжийг Аймаг, нийслэл авахаар хуульчилсан байсан бол одоо бүгдийг нь улсийн төсөвт төвлөрүүлсэн нь төвлөрлийг сааруулж байна. |
| Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого | | |
| <ul style="list-style-type: none"> улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалгат бүтээгдэхүүний санхүүжилт /10.2.3/ | — | Өмнө нь аймаг, нийслэл нь үйл ажиллагааны бүх зардлыг бие даан шийдвэрлэх боломжгүй байсан нь төсвийн төвлөрөл их байсныг илтгэж байсан. Харин шинэ хуулиар шууд ийм агуулгатай заалт үгүй байгаа нь төсвийг сааруулсан гэж үзэж болно. |
| Сум, дүүргийн төсвийн татварын орлого | | |
| <ul style="list-style-type: none"> улсын тэмдэгтийн хураамж /10.3.3/ | энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж /23.8.3/ | Тэмдэгтийн хураамжийн тухай хуулин зөвхөн 35 дугаар зүйлд заасан төлбөр хураамжийг Аймаг, нийслэл авахаар хуульчилсан байсан бол одоо бүгдийг нь улсийн төсөвт төвлөрүүлсэн нь төвлөрлийг сааруулж байна. |
| <ul style="list-style-type: none"> байгалийн баялаг ашиглахад олгох зөвшөөрлийн хураамж /10.3.5/ | ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж /23.8.5/ | Ашигт малтмал болон ашигт малтмалаас бусад байгалийн баялаг гэж ялган төлбөр багатай орлогыг сум дүүрэгт үлдээсэн нь төсөв төвлөрч байна гэж үзэх боломжтой. |
| <ul style="list-style-type: none"> ус, рашаан ашигласны төлбөр /10.3.9/ | хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр /23.8.9/ | Усны төлбөрийг ундны болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах гэж ялгаад төлбөр багатай орлогыг нь сум дүүрэгт үлдээсэн нь төсөв төвлөрч байна гэж үзэх боломжтой. |
| <ul style="list-style-type: none"> ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25 хувь /10.3.11/ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10 хувь /10.3.12/ | — | Энэ төрлийн төлбөрүүдийг 100% улсын төсөвт хурааж авч байгаа нь төсвийн төвлөрөл өндөр байгааг харуулж байна. |
| Байхгүй | нохойны албан татвар /23.8.11/ | Ийм төрлийн татвар шинээр бий болгож орон нутагт шилжүүлсэн нь төсвийн төвлөрийг сааруулах алхам болсон. |

Хоёр. Төсвийн төвлөрлийн тоон үзүүлэлт /2012 - 2015¹³он/


Монгол Улсын 2012-2015 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтээр дараах гурван үзүүлэлтийг нарийвчлан үзлээ. Үүнд:

- нэгдсэн төсвийн орлогод ДНБ-ий эзлэх хувь,
- орон нутгийн төсвийн орлогод ДНБ-д эзлэх хувь,
- нэгдсэн төсвийн орлогод орон нутгийн төсвийн эзлэх хувь,

Хүснэгт 1.

- Монгол улсын төсвийн төсөөллийн үзүүлэлтээр ДНБ-д нэгдсэн төсвийн орлого эзлэх хувь (сая төгрөгөөр)

| | Нэгдсэн төсвийн орлого | ДНБ (оны үнээр) |
|------|------------------------|-----------------|
| 2013 | 7,473,004.1 | 19,070,400 |
| 2014 | 8,864,631.7 | 24,143,200 |
| 2015 | 10,219,676.4 | 29,079,700 |




Нэгдсэн төсвийн орлогын ДНБ - д эзлэх хувь

Хүснэгт 2.

- Монгол улсын төсвийн төсөөллийн үзүүлэлтээр ДНБ-д орон нутгийн төсвийн орлого эзлэх хувь (сая төгрөгөөр)

| | Орон нутгийн төсвийн орлого | ДНБ (оны үнээр) |
|------|-----------------------------|-----------------|
| 2013 | 782,395.2 | 19,070,400 |
| 2014 | 933,626.4 | 24,143,200 |
| 2015 | 1,065,020.7 | 29,079,700 |

¹³ Урьдчилсан байдлаар тоог авсан.




Орон нутгийн төсвийн орлогын ДНБ - д эзлэх хувь

Хүснэгт 3.

- Монгол улсын төсвийн төсөөллийн үзүүлэлтээр нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн орлого эзлэх хувь (сая төгрөгөөр)

| | Нэгдсэн төсвийн орлого | Орон нутгийн төсвийн орлого |
|------|------------------------|-----------------------------|
| 2013 | 7,473,004.1 | 782,395.2 |
| 2014 | 8,864,631.7 | 933,626.4 |
| 2015 | 10,219,676.4 | 1,065,020.7 |



Нэгдсэн төсвийн орлогод орон нутгийн төсвийн эзлэх хувь

Нэгдсэн төсвийн орлогын ДНБ -д эзлэх хувь /Зураг 1/ болон Орон нутгийн төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь /Зураг 2/ зэргийг үзэхэд орон нутагт орж байгаа орлого аажим аажмаар багасах төлөвтэй байна. Ийнхүү багасч байгаа нь төсвийн төвлөрөл цаашид нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

* * *

Гурав. Төсвийн төвлөрлийн талаарх шаардлагатай хавсралтууд**Хүснэгт 4.**

- Татварын төвлөрсөн болон төвлөрсөн бус системд илрэх эерэг, сөрөг нөхцөл байдал¹⁴

| Төвлөрсөн | | Төвлөрсөн бус | |
|--|--|--|---|
| Эерэг | Сөрөг | Эерэг | Сөрөг |
| Эдийн засгийн нэгдсэн бодлого, зохицуулалт | Орон нутгийн нөөц бүрэн дүүрэн ашиглагдахгүй байх | Орон нутгийн нөөцийн ашиглалт | Макро зохицуулалт сулрах |
| Орон нутгаа хянах | Орон нутгийн санаачлага буурах, бэлэнчлэх | Идэвхи санаачлага өрсөлдөөн | Засгийн газрын хяналт |
| Татварын ачаалал орон нутагт жигд | Орлогын дахин хуваарилалтаас үүсэх хүнд суртал, зардал | Уяан хатан | Татвар төлөгчид харилцан адилгүй татвар төлөх |
| | Орон нутгийн чанартай бодлого, зохицуулалт | Орлогоо төлөвлөх боломж | Бүс нутаг хоорондын тэгш бус байдал |
| | Зардалын хариуцлага сул | Зардалын хариуцлага өндөр | Шилжилт |
| | Үүрэг, хариуцлагын зөрчил | Орон нутгийн захиргааны шуудхай ажиллагааг нэмэгдүүлэх замаар үр ашгийг дээшлүүлэх | |
| | Тодорхой бус байдал | Иргэдийн оролцоо, ил тод байдал | |

Хүснэгт 2.

- Орон нутгийн татварын хувь, хэмжээг тогтоох субъект¹⁵

| УИХ-аас хувь хэмжээг тогтоодог орон нутгийн татваруудын төрөл | Засгийн газар хувь, хэмжээг тогтоодог орон нутгийн татвар | Аймаг, нийслэлийн ИТХ хувь, хэмжээг тогтоодог орон нутгийн татвар | Орон нутгийн төсвийн татварын орлого | |
|---|---|---|--------------------------------------|------------|
| | | | Аймаг, нийслэл | Сум дүүрэг |
| Татварын ерөнхий хуулийн 7-8-р зүйлүүд | | | | |
| • албан татвар: | | | | |

¹⁴ Татварын бодлогын үндсэн асуудал. “Мянганы хөгжлийн зорилт – 9: Төсвийн үйл явц дахь иргэний нийгмийн оролцоо” сэдэвт сургалт. МХЗ-9 төслийн баг, Удирдлагын академи. 2009.03.23.

¹⁵ УИХ-ын Тамгын газар Судалгааны төв “Орон нутгийн татварын эрх зүйн зохицуулалт, гадаадын зарим орны туршлага” Харьцуулсан судалгаа.

| | | | | |
|--|---|---|---|---|
| 1. хувь хүний орлогын, | | | | + |
| 2. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын, | | | | + |
| 3. бууны, | | | | + |
| 4. үл хөдлөх эд хөрөнгийн, | | | + | |
| 5. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн, | | | + | |
| 6. хотын, | | | + | |
| 7. нохойны | | | | |
| 8. өв залгамжлал, бэлэглэлийн | | | | |
| • төлбөр: | | | | |
| 9. газрын, | + | | + | |
| 10. агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж; | + | | | + |
| 11. ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны, | + | | | + |
| 12. ус, рашааны нөөц ашигласны, | + | + | | + |
| 13. байгалийн ургамал ашигласны, | | + | | + |
| 14. түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны, | | | | + |
| • хураамж: | | | | |
| 15. ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн, | | | | + |
| 16. улсын тэмдэгтийн хураамж. | | | | + |
| Нэгдсэн төсвийн хуулийн 10-р зүйлийн 10.1, 10.3 дахь заалт | | | | |
| 17. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 20%, | | | + | |
| 18. ашигт малтмалын хайгуулын болон ашиг-лалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25%, | | | + | |
| 19. цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар, | | | + | |
| 20. ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 25%, | | | | + |

| | | | | |
|---|--|--|--|---|
| 21. ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10%. | | | | + |
|---|--|--|--|---|

Хүснэгт 3. Төлбөр тооцох үзүүлэлт

| | |
|---------------------------------|--|
| Газрын төлбөр | <ul style="list-style-type: none"> бэлчээрийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг уг бэлчээрийн нэгж талбайн суурь үнэлгээний хувиар хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам, тээвэр, холбоо мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогддсон зам, шугам сүлжээний газрын километр тутмаас дээр дурдснаар бусад газрын төлбөрийг нэг га газрын суурь үнэлгээний хувиар. |
| Агнуурын нөөц ашигласны төлбөр | <ul style="list-style-type: none"> биет хэмжээ (тоо толгой), борлуулалтын орлого, ан, амьтаны толгой тутмын экологи эдийн засгийн үнэлгээ, ан олзворын гадаад зах зээлийн тухайн үеийн үнэ буюу эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг үнэ. |
| Мод, түлээ ашиглах төлбөр | <ul style="list-style-type: none"> ургаа мод огтолж түүний үндсэн хэсгээс бэлтгэсэн хэрэглээний мод, түлээг нягт шоометрээр, үзүүр, мөчрийг сийрэг шоометрээр, ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг цэвэрлэж түлээ бэлтгэхэд сийрэг шоометрээр, иргэн заг түүж бэлтгэхэд тонн гэсэн үзүүлэлтээр. |
| Ус, усан орчин ашигласны төлбөр | <ul style="list-style-type: none"> усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамир зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус, усан орчин ашигласан тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүн, хүн амын унд, ахуйн болон иргэн, ААН, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усны шоометрээр. |
| Рашаан ашигласны төлбөр | <ul style="list-style-type: none"> эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашигласан бол эмчлэн сувилуулсан хүн-хоногийн тоо, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа бол ашигласан рашааны шоометр, халаалтын зориулалтаар ашиглаж байгаа бол хапааж байгаа зүйлийн эзлэхүүн. |

* * *

Дүгнэлт:

Засгийн газар орон нутгийн хоорондын төсвийн харилцааны талаар тогтсон нэгдсэн зарчим, онол үгүй юм. Төсвийн тухай хууль нь төсвийн харилцааг зохицуулах суурь хууль байх учиртай ба бусад холбогдох хууль тогтоомж, тухайлбал татварын багц хууль нь энэхүү хуулийн үзэл санаа, зарчимд нийцсэн байх нь учиртай.

Төсвийн хэт төвлөрлийг сааруулж, зохих хариуцлагыг ч төв болон орон нутагт зохистой хуваарилах шаардлагатай. Хуулинд орон нутгийн төсвийн харилцааны асуудлыг тусгайлан оруулж өгсөн нь сайшаалтай ч асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, орон нутагт татварын хувь хэмжээ тогтоох, хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх зэрэг эрх мэдлийг тодорхойлоогүй байна. Зарим судлаачид төвлөрлийг сааруулж

орон нутгийн шийдвэр гаргах эрхийг өргөжүүлэх нь эх үүсвэрийг зөв дайчлах, зардлыг зөв хийх, хянахад илүү дөхөмтэй, иргэдийн эрх ашигт илүү нийцдэг, тэдний оролцоо идэвх санаачлагыг ч илүү урамшуулдаг гэж үздэг.

Энэхүү судалгааны нэгдүгээр хэсэгт 2002 оны Нэгдсэн төсвийн тухай хууль болон 2011 оны Төсвийн тухай хуулиудын улсын төсвийн орлого болон орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын өөрчлөлтийг харьцуулан үзэж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. 2002 оны Нэгдсэн төсвийн тухай хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувь, ашигт малтмалын хайгуулын болон ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50 хувийг улсын нэгдсэн төсөвт, үлдсэн хувийг Аймаг, нийслэлийн болон сум дүүргийн татварын орлогод оруулдаг байсныг шинэ хуулиар 100 хувь улсын нэгдсэн төсөвт оруулахаар болсон байна.

Уул уурхайн салбар хөгжиж байгаа өнөө үед ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, нөөц ашигласаны төлбөрийг ийнхүү улсын төсөвт оруулж байгаа нь төсвийн төвлөрөл өндөр болгох магадлалыг бий болгож байна.

Нөгөө талаас орон нутаг, засаг захиргааны нэгжүүдийн хөгжлийн төвшин, орлогын суурь нь хэт ялгаатай байгаагаас орон нутгийг өөрийн эх үүсвэрээр зардлаа хангах шаардлага тавих нь боломжгүй зүйл юм. Учир нь төрийн бодлого, төрийн үйлчилгээг ижил нэг түвшинд явуулах боломжгүй гэсэн үг юм. Иймээс орон нутагт орлого ихээр төвлөрөх боломжтой ашигт малтмалын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэнээр төрийн бодлогыг орон нутагт жигд хүрээмжтэй явуулах эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

2. 2002 оны Нэгдсэн төсвийн тухай хуулиар ус ашигласаны төлбөрийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлдэг байсан. Тэгвэл 2011 оны Төсвийн тухай шинэчилсэн хуулиар ус ашигласаны төлбөрийг үйлдвэр үйлчилгээний буюу хүн амын ундны хэрэгцээний гэж ангилан зохицуулсан байна. Аймаг, нийслэлийн төсвийн орлогод нөлөө үзүүлэх боломжтой үйлдвэр үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг шилжүүлэн, сум дүүргийн төсвийн орлогод хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний зориулалтын ус ашигласаны төлбөрийг шилжүүлсэн нь төсвийн төвлөрөл бий болгосон гэж үзэх магадлалтай юм.
3. 2002 оны Нэгдсэн төсвийн тухай хуулиар Аймаг, нийслэлтийн төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд үйл ажиллагааны бүх зардлыг бие даан шийдвэрлэх боломжгүй байсан нь төсвийн төвлөрөл их байсныг илтгэж байсан. Харин 2011 оны Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

Энэхүү зохицуулалтаар Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хувьд Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр хуульчилсан байна. Үүнд:

- сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол;
- соёлын үйлчилгээ;
- эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;
- газрын харилцаа, кадастр;
- хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ;
- нийтийн биеийн тамир.

4. 2011 оны Төсвийн тухай хуулиар сум, дүүргийн орлогод Ашигт малтмал болон



ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийг төвлөрүүлэхээр хуульчилсан байна. Байгалийн баялагыг ашигт малтмалын болон бусад байгалийн баялаг гэж ялган авч үзсэн нь төлбөр багатай орлогыг сум дүүрэгт үлдээсэн нь төсөв төвлөрч байна гэж үзэх боломжтой.

Шинэчилсэн хуулийн энд авч үзсэн зохицуулалтуудаас харахад төсвийн төвлөрөл их байна, эсвэл багасах нь хэмээн шууд дүгнэхэд учир дутагдалтай юм. Учир нь тухайн зохицуулалтын өөрчлөлтөөр хэдий хэр орлого орох, түүнийг хаана хэрхэн хуваарилахыг тодорхой харах боломжгүй учраас. Харин үүнийг тодруулах гол үзүүлэлт нь төсвийн орлогын талаарх тоон үзүүлэлтүүд юм.

Шинэчилсэн Төсвийн тухай хууль ирэх 2013 оноос хэрэгжих учраас одоогоор тодорхой бодитой тоон үзүүлэлтүүд гараагүй байгаа бөгөөд судалгаанд Сангийн яамнаас гаргасан төсвийн төсөөллийн тоон үзүүлэлтийг хэрэглэлээ. Тиймээс энэ судалгааны үр дүнг бодитой болсон гэж үзэх нь учир дутагдалтай. Тиймээс дээрх үзүүлэлтээс гарсан үр дүнг ерөнхийд нь тоймлон авч үзвэл: Хэдий хуулийн холбогдох заалтууд ерөнхийдөө төсвийн төвлөрөлийг бууруулахаар чиглэлээр зохицуулагдсан байгаа ч тоон шинжилгээний үр дүнгээс үзэхэд бодит байдал дээр цаашид төсвийн төвлөрөл нэмэгдсэн хэвээр байх нь ажиглагдаж байгаа юм.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН